



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот

Сургалтанд оролцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эрүүл мэндийн ажилтныг өндөр хөгжилтэй оронд мэргэшүүлэх сургалтанд хамруулах 2016 он хүртэлх тэргүүлэх чиглэл” батлах тухай 185 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Хяналтын тоо, сургалтын зардал батлах” тухай 141 дүгээр тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Эрүүл мэнд, спортын салбарт ажиллагсдын мэргэжил, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Тайланд улсад зохион байгуулагдах Эрүүл мэндийн статистик үзүүлэлт, өвчний олон улсын ангилал, статистик судалгааны чиглэлээр сургалтанд хамрагдах эрүүл мэндийн ажилтны нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Сургалтанд эрүүл мэндийн ажилтнуудыг бүрэн хамруулахыг холбогдох байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай
3. Сургалтанд шаардагдах зардлыг 2015 оны Эрүүл мэндийн ажилтны гадаад сургалтын зардлаас гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал (Ч.Бат-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д даалгасугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

081096

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 24 өдрийн
323 дугаар тушаалын хавсралт



**Сургалтанд хамрагдах эрүүл мэндийн
мэргэжилтний нэрс**

	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Г.Ариунтуяа	Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төв	Нийгмийн эрүүл мэндийн тандалт, мэдээллийн албаны дарга
2	Г. Базархүрэл	Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Мэргэжилтэн
3	Х. Нарантуяа	Эрүүл мэнд хөгжлийн төв	СТСМА-ы мэргэжилтэн
4	Б. Норолхоосүрэн	Эрүүл мэнд хөгжлийн төв	СТСМА-ы мэргэжилтэн
5	С.Цэгмэд	Халдвар өвчин судлалын үндэсний төв	Статистикч их эмч
6	Г. Дэлгэрсүрэн	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
7	Б. Болорцэцэг	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Статистикч их эмч
8	Б. Наранцэцэг	Өвөрхангай аймаг Эрүүл мэндийн газар	Статистикч их эмч
9	Р.Баярмаа	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн Нэгдэл	Статистикч их эмч
10	Г.Түвшинжаргал	Ховд аймаг Эрүүл мэндийн газар	Статистикч их эмч